



САНГИЙН ЯАМ

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан Сангийн сайдын дангаар болон бусад сайдтай хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний 2022 оны байдлаарх хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үр дүнд үнэлгээ өгсөн тайланг танилцуулж байна.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2022 оны байдлаарх хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд нийт 38 арга хэмжээнээс Сангийн сайдын хариуцан хэрэгжүүлэх үүрэгт хамааралгүй 1 арга хэмжээ, үнэлэх боломжгүй 2 арга хэмжээг хасаж тооцвол 35 арга хэмжээнээс 24 арга хэмжээ 100.0 хувийн, 11 арга хэмжээ 90.0 хувийн хэрэгжилттэй, ерөнхий дүнгээр 98.4 хувьтай байна.

**Засгийн газрын Үйл ажиллагааны хөтөлбөр
Сангийн яам 2022 оны жилийн эцэс**

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хариуцсан газар	СЯ-ны үнэлгээ	ЗГХЭГ-ын үнэлгээ
НЭГ. КОВИД-19 ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО									
1	1.1.7. Цар тахлаас үүдсэн эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулахад чиглэсэн дэмжлэг, туслалцааг нэмэгдүүлэх чиглэлээр хөгжлийн түнш улс орнууд, олон улсын байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллана.	2. Цар тахлаас үүдсэн эдийн засаг, нийгмийн эмзэг бүлэгт үзүүлэх хүндрэлийг даван туулахад чиглэсэн хөтөлбөрийн зээлийг Азийн хөгжлийн банктай тохирч, идэвхтэй хамтран ажиллана. /200.0 сая ам.доллар/	2020 - 2022		2 үе шаттай төсвийн алдагдлыг нөхөх хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эх үүсвэрийг хүлээж авна.	АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй “ Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл”- ийн хүрээнд улсын төсвөөс олгосон хүүхдийн мөнгөний нөхөн санхүүжилтэд 2020 онд 60.7 тэрбум, 2021 онд 119.5 тэрбум, 2022 онд 82.6 тэрбум төгрөгийг олгоод байна.	ХСХОГ	100%	100%
2	1.1.9. Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн чөлөөт мөнгөн хөрөнгийг оновчтой удирдах замаар Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээ, зардлыг бууруулах арга хэмжээ авна.	1. Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн чөлөөт мөнгөн хөрөнгийг оновчтой удирдах замаар Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээ, зардлыг	2021 - 2024		Эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	Сангийн сайд, Монгол банкны ерөнхийлөгчийн хамтарсан 2022 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн А122/А-172 тоот тушаалаар “Засгийн газрын болон төсвийн байгууллагын банканд нээх, хаах, тайлагнах журам” батлуулсан. Дээрх журмаар Засгийн газрын болон төсвийн байгууллагын мөнгөн хөрөнгийг эрсдэлд оруулахгүй байх үүднээс төсвийн байгууллага банканд шинээр данс нээлгэх хүсэлт ирүүлсэн үед журмын 2.3 Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүсэлтийг ажлын 5 өдрийн дотор хянаж энэ журмын 2.1-д заасан дараах шалгуурыг хангасан банканд данс нээх зөвшөөрлийг олгоно: 2.3.1 Монгол банкнаас тогтоосон банкны өөрийн	ТСГ	100%	70%

		бууруулах арга хэмжээг авна.				хөрөнгийн хүрэлцээ, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, гадаад валютын зохистой харьцаа, заавал байлгах нөөцийн шаардлагын үзүүлэлтийг сүүлийн 6 сар тасралтгүй хангасан байх;2.3.2 Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан хязгаарлалтыг сүүлийн 6 сар тасралтгүй хангасан байх;2.3.3 Хамгийн сүүлд хийгдсэн зохистой засаглалын үнэлгээгээр 65 ба түүнээс дээш онооны үнэлгээтэй байх. 2.4 Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 2.3 дах хэсэгт заасан зөвшөөрлийг олгохдоо банканд байршиж буй Монгол Улсын Засгийн газрын болон төсвийн байгууллагын банк дах өглөг, харилцах, хадгаламжийн дансны нийт мөнгөн хөрөнгө нь тухайн улирлын банкны нийт активын 30 хувиас хэтрэхгүй байх зарчмыг баримтална. гэсэн зохицуулалтуудыг шинээр оруулж өгсөн.			
ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО									
3	2.1.7. Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн оновчтой арга, хэлбэрийг нэвтрүүлж, эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний нэр, төрлийг нэмэгдүүлж, эрсдэлийн сан байгуулна.	10. Эрүүл мэндийн даатгалыг цахимжуулна.	2021 - 2024		Эрүүл мэндийн даатгалын цахим тогтолцоог бий болгож, бүх шатны эрүүл мэндийн байгууллагыг холбоно.	Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлж, Эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн 2021 оны 03 дугаар тогтоол гарсан. Уг тогтоол батлагдсанаар оношийн бүлэг тус бүрээр эрүүл мэндийн байгууллагуудад үзүүлсэн тусламж, үйлчилгээний чанар үр дүнд суурилсан санхүүжилт олгож байна. Тусламж, үйлчилгээний санхүүжилт гүйцэтгэлээр олгоход зориулж ЭМДСангийн 2021 оны төсөвт 1.0 их наяд төгрөгийн төсөв тусгасан. УИХ-ийн 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн чуулганаар Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн хуулийг баталсан.Эрүүл мэндийн даатгалыг цахимжуулах ажлын хүрээнд 1/ Иргэд даатгуулагчдад зориулсан 1818.mn цахим хуудсыг шинээр нээн ажиллуулсан, 2/e-daatgal гар утасны апплейшн хэрэглээнд нэвтрүүлсэн, 3/ Эрүүл мэндийн даатгалын цахим нэгдсэн	ТБТГ	100%	100%

					системд бүх шатны эрүүл мэндийн байгууллагыг холбож төлбөрийн нэхэмжлэлийн хяналтыг хэрэгжүүлж байна.				
4		11. Төрөөс хариуцах иргэдийн шимтгэл, албан бус салбарын даатгуулагчдын хамрагдалт, шимтгэлийн хэмжээг өсгөх замаар Улсын төсөв /ЭМДС/гийн орлогыг нэмэгдүүлнэ.	2021 - 2024		ЭМД-ын тухай хуулийн 6.1.2, 6.1.3, 6.1.5, 6.1.9, 6.1.12-д заасан даатгуулагчийн шимтгэлийн хувь, хэмжээг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 2-оос доошгүй хувиар, 6.1.4-т заасан даатгуулагчийн шимтгэлийн хувь, хэмжээг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 4-өөс доошгүй хувиар тус тус тогтооно.	Төрөөс хариуцах иргэдийн шимтгэл, албан бус салбарын даатгуулагчдын хамрагдалт, шимтгэлийн хэмжээг өсгөх замаар төсвийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлд ЭМЯ-аас тухайлсан үе шаттай судалгаа хийж, дүгнэлт гаргасны үндсэн дээр яамдуудаас санал авахаар бэлтгэж байна.	ТБТГ	100%	50%
5	2.6.3. Соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлж, үндэсний агуулгатай инновац шингэсэн соёлын бүтээлч үйлдвэрлэл-инновацийн салбарыг хөгжүүлж, монгол брэндийг бий	5. Соёлын удирдлага, зохион байгуулалтын нэгдсэн тогтолцоог боловсронгуй болгож, санхүүжилтийн олон эх үүсвэртэй, хүртээмжтэй, үр ашигтай механизмыг бүрдүүлэн соёлын	2021 - 2025		Бүтэц, орон тооны дагуу аймаг, нийслэлийн нутаг дэвсгэр дэх соёл, урлагийн үйл ажиллагааг удирдан, зохион байгуулна. Соёл, урлагийн байгууллагыг батлагдсан стандартын дагуу	Соёлын салбарын чанар, гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн шинэчлэлийг эхлүүлэх бэлтгэл ажил болгож 21 аймагт шинээр Соёл, урлагийн газрыг байгуулсан бөгөөд аймгуудын Соёл, урлагийн газар нь 210.0 сая төгрөгийн үйл ажиллагааны төсөвтэй, 11 орон тоотойгоор 2022 онд үйл ажиллагаа явуулж байна. Мөн нийслэл Улаанбаатар хотын Соёл, урлагийн газрыг Соёлын сайдын харьяанд шилжүүлсэн. Аймгуудын театр, чуулга, музей, номын сан болон сумдын соёлын төв зэрэг орон нутагт соёлын үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын харьяаллыг орон нутгаас	ТБТГ	100%	70%

	болгож, соёл, урлагийн эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.	үйлчилгээг иргэдэд чанартай, шуурхай хүргэнэ.			зохион байгуулж ажиллуулах ажлыг эхлүүлнэ. 11 аймагт Соёл, урлагийн газрын барилга угсралтын ажлыг эхлүүлнэ.	улсын төсөв рүү шилжүүлж, Соёлын сайдын багцад үйл ажиллагаа явуулах өөрчлөлтийг хийсэн. Ингэснээр соёлын нэгдсэн бодлогыг аймгуудын соёл урлагийн газраар дамжуулж соёлын үйлчилгээ үзүүлэгч бүх байгууллагуудад нэгдсэн байдлаар хэрэгжүүлэх, соёлын салбарын бүтээлч үйлдвэрлэлийг нэгдмэл удирдлагаар хангах замаар хэрэгжүүлэх боломжтой болсон. Мөн Засгийн газраас хэрэгжүүлж байгаа соёлын салбарын санхүүжилтийн шинэчлэлийн хүрээнд соёлын үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын төсвийг орцод суурилсан байдлаар цалин хөлс, үйл ажиллагааны зардал төлөвлөдөг байсныг 2022 оноос гүйцэтгэлийн санхүүжилт рүү шилжүүлж орон нутгийн соёлын байгууллагуудад гүйцэтгэлээр олгох санхүүжилт байдлаар бөөн дүнгээр төлөвлөж, соёлын үйлчилгээ үзүүлэгч байгууллагын үзүүлсэн үйлчилгээний хэмжээ, чанараар санхүүжүүлдэг болох бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна.			
ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО									
6	3.1.2. Эдийн засгийн эрсдэлээс сэргийлж, эдийн засаг өсөлттэй үед төсвийг тогтворжуулж, хямралтай үед тэлэх мөчлөг сөрсөн төсвийн бодлого хэрэгжүүлнэ.	1. Эдийн засгийн эрсдэлээс сэргийлж, эдийн засаг өсөлттэй үед төсвийг тогтворжуулж, хямралтай үед тэлэх мөчлөг сөрсөн төсвийн бодлого хэрэгжүүлнэ.	2020 - 2024		Үйл ажиллагааны хэрэгжилтээр	2020 онд эдийн засгийн өсөлтийг -4.6%, Төсвийн алдагдал ДНБ-ий -12.0% байсан бөгөөд 2021 оны төсвийн бодлогоор эдийн засгийн өсөлтийг 5.0%, Төсвийн алдагдлыг -5.1%-р тооцсон нь Эрдэс бүтээгдэхүүний үнэ өндөр, Төсвийн багц арга хэмжээ 2.4 их наяд, эдийн засгийг хагас нээж, 10 их наядын хөтөлбөрийг хэрэгжүүлж, эрүүл мэндийн салбарын зардал нэмэгдэж, хүүхдийн мөнгө 100.000₮ болж хэрэгжүүлсэн.	ТБТГ	100%	70%
7	3.1.3. Банкны салбарын шинэчлэлийг богино хугацаанд	1. Банкны тухай хууль, Төв банкны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн	2020 - 2024		Эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна.	Монгол Улсын Их Хурлын 2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаар баталсан Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар системийн нөлөө бүхий банкууд			

	хийж, банк, санхүүгийн байгууллагуудын өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтийг өртөг багатай санхүүжилтээр дэмжиж, банкны зээлийн сарын хүүг 1 хувиас хэтрүүлэхгүй болгож, эрсдэл даах чадамжтай болгоно.	этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль зэрэг хууль, тогтоомж холбогдох журамд өөрчлөлт оруулна.				нээлттэй хувьцаат компани хэлбэртэй байхаар, мөн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиар энэхүү шилжилтийг буюу компанийн хэлбэрээ өөрчлөх асуудлыг 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор багтаж өөрчилсөн байхаар тус тус зохицуулсан. Арилжааны банкнуудыг нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжихээс өмнө Монгол банкнаас эдгээр банкнуудад активын чанарын үнэлгээг хийх шаардлага тавигдсаны дагуу банкнуудын IPO хийх хугацааг нэг жилээр буюу 2023.06.30-ны өдөр хүртэл сунгах зохицуулалтыг УИХ-ын 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцсэн Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар баталсан. Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Төрийн банк олон нийтэд нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжих анхдагч арилжааны нээлтээ Монголын Хөрөнгийн биржид 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр хийн, хувьцаагаа олон нийтэд санал болгон, IPO амжилттай хийгээд байна. Арилжааны банкнууд олон нийтэд нээлттэй хэлбэрт амжилттай шилжсэнээр өөрийн хөрөнгөө нэмэгдүүлж, засаглалын хувьд илүү илтэд, нээлттэй болж, банкны салбар, хөрөнгийн зах зээл өргөжиж, эдийн засгийн өсөлтийг дэмжиж нөхцөлийг бүрдүүлнэ гэж үзэж байна.	СБГ	100%	70%
8	3.1.4. Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг тэтгэж, зээлийн хүүг бууруулна.	1. Санхүүгийн түрээсийн эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд Санхүүгийн түрээсийн тухай хуульд нэмэлт,	2020 - 2024	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Шинэчилсэн найруулгын төсөлд санхүүгийн түрээсийн салбарыг зохицуулагч этгээдээр Санхүүгийн зохицуулах хороог байхаар тусгасан бөгөөд тус асуудлаар салбарын оролцогч талуудтай хэлэлцүүлэг зохион байгуулахад, заавал зохицуулагч этгээд байх шаардлагатай эсэх, байвал заавал СЗХ байх эсэх зэрэг зарчмын зөрүүтэй саналууд гарсан тул асуудлыг цааш судлах шаардлага бий болсон. Иймд хуулийн төслийг 2023 онд өргөн мэдүүлэхээр	СБГ	90%	30%	

		өөрчлөлт оруулна."				хойшлуулж шаардлагатай судалгааг хийж байна.			
9	3.1.5. Санхүүгийн түрээсийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	1. Санхүүгийн түрээсийн тухай хууль-д нэмэлт өөрчлөлт оруулах замаар хууль, эрх зүйн орчныг сайжруулна.	2020 - 2024		Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Шинэчилсэн найруулгын төсөлд санхүүгийн түрээсийн салбарыг зохицуулагч этгээдээр Санхүүгийн зохицуулах хороог байхаар тусгасан бөгөөд тус асуудлаар салбарын оролцогч талуудтай хэлэлцүүлэг зохион байгуулахад, заавал зохицуулагч этгээд байх шаардлагатай эсэх, байвал заавал СЗХ байх эсэх зэрэг зарчмын зөрүүтэй саналууд гарсан тул асуудлыг цааш судлах шаардлага бий болсон. Иймд хуулийн төслийг 2023 онд өргөн мэдүүлэхээр хойшлуулж шаардлагатай судалгааг хийж байна.	СБГ	90%	30%
10	3.1.6. Иргэдийг санхүүгийн эрсдэл, дарамтад өртөхөөс сэргийлэх, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль, эрх зүйн орчныг шинээр бүрдүүлэх замаар мөнгө хүүлэлтийг таслан зогсооно.	1. Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хуулийн төслийг боловсруулж УИХ-аар хэлэлцүүлэн батлуулна.	2020 - 2024		Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хуулийн төслийг батлуулсан байна.	АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй төслийг Монгол банк ахлан Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хуулийн төслийг боловсруулж дуусган, хууль санаачлагчид уламжлахаар ажиллаж байна. Иймээс энэ арга хэмжээг Сангийн яамны хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээнээс хасах саналтай байна.	СБГ	100%	30%
11	3.1.7. Иргэн, хуулийн этгээд хөрөнгийн биржийн арилжаанд сүүлийн үеийн дэвшилтэт технологид тулгуурласан, цахим арилжааны дэд бүтцээр шууд оролцох	1. Сүүлийн үеийн дэвшилтэт технологи дээр тулгуурласан, хөрөнгийн зах зээл дээр ашиглагдах цахим арилжааны дэд бүтцийг нэвтрүүлж, иргэд, хуулийн этгээдэд	2021 - 2022		Арилжааны дэд бүтэц дээр нэмэлт хөгжүүлэлтийг гүйцэтгэж, хөрөнгийн бирж дээрх арилжаалагдаж буй хувьцаа, компанийн бонд болон бусад	Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжаанд орчин үеийн дэвшилтэт технологийг ашигласан системийг нэвтрүүлж, арилжааг эхлүүлэх ажлын хүрээнд Засгийн газрын үнэт цаасыг блокчейн технологи дээр суурилсан платформаар зохион байгуулахаар "Юби Сток Эксченж" ХХК болон Хаан банк, Төрийн банк, Голомт банкнуудтай төстийн орчинд үүсгэн арилжааны системийг төстэлж дуусаж бодит төстийн орчинд арилжаа зохион байгуулах ажлууд бүрэн хийгдэж дууссан.Засгийн газрын дотоод үнэт цаасны	СБГ	100%	70%

	боломжийг бүрдүүлнэ.	арилжаанд орох замаар санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.			санхүүгийн бүтээгдэхүүнүүд арилжаалах боломжийг нэвтрүүлж дууссан байна.	арилжаа зохион байгуулах талаар холбогдох тушаал, шийдвэр гараагүй тул 2022 оны байдлаар ямар нэгэн арилжаа хийгдээгүй болно.			
12	3.1.8. Банк, санхүүгийн систем дэх чанаргүй зээлийг шуурхай, зардал багатай шийдвэрлэх хууль, эрх зүйн шинэчлэл хийнэ.	1. Банк, санхүүгийн систем дэх чанаргүй зээлийг шуурхай, зардал багатай шийдвэрлэх хууль, эрх зүйн шинэчлэл хийнэ.	2020 - 2024		Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Хуулийн этгээдийн төлбөрийн чадваргүйдлийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх, төлбөрийн чадваргүй хуулийн этгээдийг дахин хөрөнгөжүүлэх, татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулахаар Засгийн газраас Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төслийг 2022 оны 3 дугаар сарын 14-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн. Хуулийн төсөлд хуулийн этгээдийн төлбөрийн чадвартай эсэхийг тогтоох, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх, нэхэмжлэлийн шаардлагыг ангилах, хангах, хэрэг гүйцэтгэгчийн томилох, чөлөөлөх, нэхэмжлэгчдийн хурал, түүний эрх хэмжээ, хуралд оролцох саналын эрх, хуваарилагдах хөрөнгө, хуулийн этгээдийг дахин хөрөнгөжүүлэхтэй холбогдсон асуудлыг нарийвчлан тусгасан. УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны 2022.10.12-ны өдрийн хуралдаанаар тус хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжсэн.	СБГ	90%	70%
13	3.1.9. Хугацаа тулсан гадаад өр төлбөрийг макро эдийн засгийн тогтвортой байдлыг алдагдуулахгүйгээр шийдвэрлэн Засгийн газрын өрийн дарамтыг бууруулж,	1. Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичиг"-т тусгасны дагуу Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрийг дахин санхүүжүүлнэ.	2020 - 2024		Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийн 1 дүгээр зорилт, Засгийн газрын 2021 оны 65 дугаар тогтоолоор батлагдсан "Засгийн газрын гадаад үнэт цаас гаргах, арилжаалах журам"-ын 2 дугаар зүйлийн 2.4 дэх хэсгийг тус тус үндэслэн Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрийн эдийн засаг, төсөвт үзүүлэх ачааллыг жигдлэх, өрийн үйлчилгээний зардлыг бууруулах зорилгоор 2022-2023 онд эргэн төлөгдөх "Гэрэгэ" бондын 16.3 сая ам.доллар, "Чингис" бондын 2.5 сая ам.доллар буюу нийт 18.8 сая ам долларын	СБГ	100%	100%

	санхүүгийн нөөцийг бүрдүүлнэ.					Засгийн газрын гадаад үнэт цаасыг зах зээл уналттай байгаа цаг үеийг ашиглан эргэн төлөгдөх үнээс хямд өртөгтэй-ээр нээлттэй зах зээл дээрээс буцаан худалдан худалдан авах өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлээд байна. Дээрх нээлттэй зах зээл дээрээс буцаан худалдан авах өрийн зохицуулалтын үр дүнд Засгийн газрын өрийн үйлчилгээний зардлаас нийт 1.4 сая ам.долларын үндсэн болон хүүгийн төлбөрийн хэмнэлтийг улсын төсөвт гаргасан. Түүнчлэн, зээлжих зэрэглэл тогтоогч агентлагууд болон Засгийн газрын гадаад үнэт цаасны хөрөнгө оруулагчдын итгэлийг хадгалах, харилцааг сайжруулах ажлын хүрээнд тэдэнд Монгол Улсын нийгэм эдийн засаг, төсөв санхүүгийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлагын талаарх мэдээллийг тогтмол хүргэн ажиллаж, биет болон цахим уулзалтуудыг тухай бүр зохион байгуулан ажиллаж байна.			
14	3.1.10. Гадаад худалдааг дэмжсэн гаалийн үйлчилгээг хялбаршуулж, иргэдийг хууль бус, хуурамч бараанаас сэргийлэх, байгалийн баялгаас татварыг бүрэн хураахад чиглэсэн гаалийн шинэчлэлийг үргэлжлүүлнэ.	1. Барааны борлуулалтын шат дамжлага бүрийг бараа бүртгэлийн нэгдсэн системээр дамжуулан бүртгэж иргэд гар утасны "и-баримт" аппликейшн ашиглан тамхи, согтууруулах ундаа зэрэг онцгой албан татвартай бүх төрлийн бараа, эмийн бүтээгдэхүүн, мах, махан	2020 - 2024	Татварын ерөнхий газрын ач холбогдолтой барааг Бараа бүтээгдэхүүний нэгдсэн системээр дамжуулан бүртгэсэн байна.	Барааны борлуулалтын шат дамжлага бүрийг бараа бүртгэлийн нэгдсэн системээр дамжуулан бүртгэж иргэд гар утасны "и-баримт" аппликейшн ашиглан тамхи, согтууруулах ундааны гарал үүсэл, чанар зэрэгт хяналт тавих боломжийг бүрдүүлсэн.	ТБГ	100%	100%	

		бүтээгдэхүүний гарал үүсэл, чанар зэрэгт хяналт тавих боломжийг бүрдүүлнэ.							
15	3.1.11. Татварын тайлагналт, хураалтын үйл ажиллагааг цахимжуулж, ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар татварын үйлчилгээг иргэд, татвар төлөгчдөд хүндрэлгүй болгож, татварын суурийг нэмэгдүүлэх зорилгоор газар, үл хөдлөх эд хөрөнгө, буу, авто тээвэр зэрэг хувь хүнд хамаарах бүхий л татварын нэхэмжлэлийг цахим төлбөрийн баримтын системээр хүргүүлэн, богино хугацаанд цахимаар, хялбар төлөх боломжийг олгоно.	1. Татварын тайлагналт, хураалтын үйл ажиллагааг цахимжуулж, ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар татварын үйлчилгээг иргэд, татвар төлөгчдөд хүндрэлгүй болгож, татварын суурийг нэмэгдүүлэх зорилгоор газар, үл хөдлөх эд хөрөнгө, буу, авто тээвэр зэрэг хувь хүнд хамаарах бүхий л татварын нэхэмжлэлийг цахим төлбөрийн баримтын системээр хүргүүлэн, богино хугацаанд цахимаар, хялбар төлөх боломжийг олгоно.	2020 - 2023		Хөрөнгийн бүртгэл хийдэг байгууллагуудыг холбосон нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлж, "и-баримт" аппликейшн ашиглан татвар ногдуулах, төлөх технологийг нэвтрүүлнэ.	"И-баримт" аппликейшн ашиглан үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, малын тоо толгойн албан татвар, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, газрын төлбөр, галт зэвсгийн албан татварын нэхэмжлэхийг цахимаар хүргүүлж, төлөх боломжийг бүрдүүлсэн.	ТБГ	100%	100%
16	3.1.12. Төсөв, санхүүгийн нэгдсэн цахим систем	1. Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн	2021 - 2024		Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Сангийн яам төсвийн байгууллага, улсын төсөвт үйлдвэрийн газруудын орон тоо, цалин хөлсний зардлын хуваарилалтад хяналт тавих, төсвийн			

<p>нэвтрүүлж, төрийн үйлчилгээг шуурхай, үр ашигтай болгож, гадаадын зээл, тусламж, төсвийн урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг ил тод, хэмнэлттэй зарцуулах нөхцөл бүрдүүлнэ.</p>	<p>удирдлага мэдээллийн системд бүртгэлтэй төрийн албан хаагчийн мэдээлэлд суурилсан Төрийн албаны цалин хөлсний нэгдсэн системийг улсын хэмжээнд нэвтрүүлнэ. Салбаруудын орон тоонд хяналт тавьж, давхардсан болон илүүдэл орон тоог илрүүлэх замаар орон тоог дахин хуваарилах, бууруулах зэргээр цалин хөлсний төлөвлөлтийг оновчтой болгож, зардлын өсөлтийг тогтворжуулна.</p>				<p>үр ашиг, сахилга батыг сайжруулах зорилгоор Төрийн албаны зөвлөл (ТАЗ)-ийн Хүний нөөцийн нэгдсэн систем (ХННС)-д агуулагдаж байгаа төрийн албан хаагчдын орон тоо, бүтэц, цалин хөлсний дэлгэрэнгүй мэдээллийг Төрийн албаны цалингийн нэгдсэн систем (ТАЦНС)-д веб-сервис холболтоор хүлээн авч боловсруулан төсвийн төлөвлөлт болон гүйцэтгэлийн процесст ашиглах зорилт тавьж, ТАЦНС-ийн функциональ шаардлага болон бизнес процесс боловсруулах, турших програм хангамж хөгжүүлэх ажлыг Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв (ГТСМТТ) улсын төсөвт үйлдвэрийн газартай хамтран гүйцэтгэж, албан хаагчдын цалин хөлсийг системээр тооцоолон, албан хаагчдын арилжааны банкны нэрийн дансанд гүйлгээ илгээж байна. ТАЦНС-ийг улс орон даяар үе шаттайгаар нэвтрүүлэх Засгийн газрын 2020 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн 163 дугаар тогтоол батлагдсан. Тогтоолын хэрэгжилтийг хангаж 2020 оны 9 дүгээр сараас үе шаттайгаар нийт 4,352 байгууллагын нягтлан бодогч, дарга нар хэрэглэгчээр бүртгүүлэн нэвтэрч цалин хөлс бодож эхэлсэн нь 100 хувийн гүйцэтгэлтэй байна. Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын Төсвийн зарлагын хэлтсийн мэргэжилтнүүд, төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагч нарын төсвийн мэргэжилтнүүдийг ТАЦНС-д хэрэглэгчээр холбох ажил хийгдсэн. Ингэснээр харьяа байгууллагуудын орон тоо, цалин хөлсний мэдээлэлд дүн шинжилгээ хийх боломжтой болох юм.(i) Төсвийн мэргэжилтнүүдэд зориулсан тайлангийн хөгжүүлэлтийг сайжруулах, (ii) ТАХ-д өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж болон Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх</p>	ТСГ,ТБТГ	90%	70%
--	---	--	--	--	---	----------	-----	-----

					дэмжлэгийг уг системээр дамжуулан олгох хөгжүүлэлтийн ажлыг хийхээр ажиллаж байна.			
17		2. Төсвийн хөрөнгө оруулалтын PIMIS системийг хөгжүүлж хөрөнгө оруулалтын талаарх цогц мэдээллийг олон нийтэд хүргэнэ.	2021 - 2022	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Төсвийн хөрөнгө оруулалтын PIMIS системийг Фискал системтэй холбосноор гүйцэтгэгчид цахим системээр дамжуулан санхүүжилтийг шууд олгох ажил амжилттай хийгдэж, гүйцэтгэлийн санхүүжилтийг гүйцэтгэгчийн дансанд шууд шилжүүлдэг боллоо. Хуучин гүйлгээний процесс дунджаар ажлын 7-14 хоног байсан бол шинэ гүйлгээний процесс 20-30 минут болсон. ТЕЗ, байгууллага, гүйцэтгэгч тал санхүүжилтийн явцын талаар бүрэн мэдээлэлтэй болсон.	ХСХОГ	100%	100%
18		3. Төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл, тусламж, концесс, орон нутгийн төсөв болон бусад эх үүсвэрээр хэрэгжиж байгаа төслүүдийн нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлнэ.	2021 - 2023	Төслүүдийн системийг холбох ажлыг эхлүүлсэн байна.	21 аймаг, нийслэлийн таван жилийн үндсэн чиглэл болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрүүдийг мэдээллийн санд нэгдсэн загварын дагуу оруулж холбон, тест сервер дээр бүртгэж дуусгасан. Хэрэгжилтийн шатны процессуудыг тодорхойлох, хөгжүүлэлт рүү шилжүүлэх ажлын хүрээнд дараах ажлууд хийгдэв. Үүнд:• Төслийн багц задлах, эрх шилжүүлэлт, гэрээ байгуулахтай холбоотой процесс зураг.• Гэрээний удирдлагын нарийвчилсан хар зураг гаргаж хөгжүүлэлтийн багт шилжүүлсэн.• Гэрээний удирдлагын нарийвчилсан хар зураг гаргаж хөгжүүлэлтийн багт шилжүүлсэн.• Багц төслийн хувьд гэрээ үүсгэх процесс болон хөгжүүлэлтийн бүдүүвч зураг гаргасан.Гүйцэтгэлийн санхүүжилтийг ААН данс руу шууд шилжүүлэг хийхийг системээс хийдэг болсонтой холбоотойгоор бүх захиалагч болон 1, 2 дугаар гарын үсэг зурхад оролцох төрийн сангийн мэргэжилтнүүдэд зориулсан сургалтыг 2022 оны 10 дугаар сарын 5-ны өдөр ТХОХэлтэс болон ТСГазрын мэргэжилтнүүдтэй хамтран зохион байгуулсан.Системийн хэвийн, тогтвортой ажиллагааг хангах ажлын хүрээнд Төрийн сангийн газраас гүйлгээ хийхийн өмнө	ХСХОГ	100%	90%

					дахин баталгаажуулж байхаар харилцан тохиролцож холбогдох туршилтуудыг хийж баталгаажуулсан. Цахимаар бүх эх үүсвэрээр хэрэгжүүлж байгаа төслүүдийн мэдээллийг авахаар төлөвлөж байна. УХОХ, зээл тусламж, ОНХС, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас Төрийн өмчит үйлдвэрийн газрын хөрөнгө оруулалтын мэдээллийг авахдаа төслүүдийг давхардуулж хэрэгжүүлэхгүй, олон эх үүсвэрээр хэрэгжүүлэх төслүүдийг цогц байдлаар бие биенээ дэмжих, хооронд нь уялдаатай төлөвлөж хэрэгжүүлэх зорилготой байна.			
19	4. Төсөв, санхүү, хөрөнгө оруулалт, худалдан авалт, тайлан бүртгэл, хяналтын системийн нэгдсэн дэд бүтцийг бий болгоно.	2021 - 2023		Системүүдийг хооронд нь холбох ажлыг эхлүүлсэн байна.	АХБ-ны төслийн хүрээнд төлөвлөлтийн дэд систем хөгжүүлэлт хийгдэж байгаа бөгөөд ТЕЗ-аас авсан саналын дагуу төлөвлөлтийн систем дээр салбар, дэд салбар, төслийн хүчин чадлыг хэмжих нэгжийг бүртгэн оруулсан бөгөөд шинэ процессын дагуу төслийн төсөл үүсгэхэд шаардлагатай төслийн баталгаажуулалтын мэдээллийн сан болон бодлогын бичиг баримттай холбох хэрэглэгчийн интерфэйсийн хэсгийг хөгжүүлсэн. Мөн хэрэглэгчийн нэгдсэн ангилал, байгууллагын бүртгэлийг системд оруулсан. Гадны системүүдийн холболтын хүрээнд Барилгын хөгжлийн төвийн мэдээллийн системтэй API сервисийн холболт хийгдэж магадлангийн дугаараар тухайн системээс магадлан хийгдсэн зураг төсөлтэй холбоотой нийт 12 төрлийн мэдээллийг авах боломжтой юм. ОНХС-ийн системтэй Сангийн яамны дундын сервис платформоор дамжин холбогдож тус системээс тухайн жилд хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийн болон төлбөртэй холбоотой мэдээллүүдийг авах боломжтой байна. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын хорооны төрийн өмчийн мэдээллийн системээс барилга байгууламж, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэлтэй	ХСХОГ	100%	90%

						холбоотой мэдээллүүдийг PIMIS систем-рүү татаж авахаар холбогдох API сервисийг хөгжүүлсэн.			
20		5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож төсөл, арга хэмжээний үр ашиг, хэрэгжилт, гүйцэтгэлийг сайжруулна.	2021 - 2024		Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийн төслийг анхны хэлэлцүүлгийг 2022 оны 11-р сарын 17-ны өдрийн УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлсэн. Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг 2022 оны 12-р сарын 01-нд УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан. Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулахаар журмын төслийг шинэчлэн боловсруулж байна.	ХСХОГ	90%	70%
21	3.1.13. Бизнесийн шударга өрсөлдөөнийг дэмжсэн, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалсан шинэчлэлийн бодлого хэрэгжүүлнэ.	5. Зар сурталчилгааны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бүтцийг бий болгож, хүн амын хүнсний болон аюулгүй байдалд сөрөг нөлөөт зар сурталчилгааг таслан зогсоох, хязгаарлах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимтэй хэрэгжүүлнэ	2020 - 2024		Хүүхдэд чиглэсэн эрүүл мэндэд сөрөг нөлөөт хүнсний бүтээгдэхүүний зар сурталчилгаанд хяналт тавих үйл ажиллагааг эрчимжүүлнэ	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах асуудал нь Монгол Улсын Шадар сайдын харьяа Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын эрхлэх асуудал бөгөөд жил бүр тус байгууллагын төсвийг батлан хэрэгжүүлдэг. Тухайлбал 2022 онд 36 орон тоо, 847.9 сая төгрөгийн төсөв батлагдан хэрэгжиж байна. 2023 оны төсвийн төсөлд 36 орон тоо 932.5 сая төгрөг тусгагдсан байна.	ТБТГ	100%	70%
22	3.1.15. Дотоодын давхар даатгал хөгжих, урт	1. Даатгалын салбарын эрх зүйн орчныг	2020 - 2024		Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Даатгалын салбарын оролцогч байгууллагууд, мөн олон нийтээс албан бичгээр болон цахим хэлбэрээр ирсэн 414 орчим саналуудыг			

	хугацааны даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлж, даатгалын салбарын эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулан салбарын тогтвортой өсөлтийг бүрдүүлнэ.	боловсронгуй болгох хүрээнд Даатгалын тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай, Жолоочийн даатгалын тухай зэрэг хууль тогтоомж болон холбогдох дүрэм, журамд өөрчлөлт оруулна.				хэлэлцэж, ирсэн саналуудын хүрээнд холбогдох мэргэжлийн байгууллагууд, төлөөллүүдтэй удаа дараагийн 2 талын уулзалтуудыг хийсэн. Эдгээр байгууллагууд, иргэдээс ирсэн саналуудын нэгтгэлийг хийж дууссан бөгөөд салбарын нийт оролцогчдын хэлэлцүүлгийг 11 сард багтаан хийхээр төлөвлөн хэлэлцүүлгийн бэлтгэл ажлыг хангаж байгаа болно. Хуулиудын шинэчилсэн найруулгад холбогдох саналуудыг тусгаснаар үндэсний давхар даатгалын тогтолцоог бэхжүүлэх, даатгалын салбарын оролцогчдод цахим дэвшилтэт техник технологид суурилсан даатгалын үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлэх, амьдралын даатгалыг хөгжүүлэх, заавал даатгалын нэгдсэн тогтолцоог бий болгох, технологид суурилсан даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг дэмжих, мэргэжлийн хөрөнгө оруулагч даатгагчдыг бий болгох, даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчин сайжрах зэрэг ач холбогдолтой бөгөөд 2022 ондоо багтааж ЗГ болон УИХ-д өргөн мэдүүлэхээр төлөвлөж байна.	СБГ	90%	50%
23	3.1.18. Хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, хөрш орнуудын хилийн боомтуудын жишигт хүргэнэ. Хилийн заставуудын барилга, объектуудыг шинэчилж чанарыг сайжруулна.	1. Хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлж сайжруулна.	2021 - 2024	Гашуунсухайт, Бичигт, Шивээхүрэн боомтуудын бүтээн байгуулалтын ажилтай зэрэгцүүлэн гаалийн хяналт шалгалт болон салбар лабораторийн тоног төхөөрөмжийг суурилуулж иж бүрэн сайжруулж, хилээр нэвтрэч	Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа гаалийн шинэчлэлийн хүрээнд Замын-Үүд, Алтанбулаг, Гашуунсухайт, Боршоо, Шивээхүрэн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор боомтын бүтээн байгуулалтын ажлууд хийгдэж байна. Мөн ОХУ-тай хиллэдэг 3, БНХАУ-тай хиллэдэг 7 буюу нийт 10 боомтыг шинээр өргөтгөн шинэчлэхээр төлөвлөсөнтэй холбогдуулан гаалийн байгууллагаас зураг төслийн компаниудтай хамтран ажиллаж, тухайн боомтуудад баригдах барилга байгууламж болон байрлуулах гаалийн хяналт, шалгалтын тоног төхөөрөмжийн тоо, байрлалыг тогтоосон.Хилийн боомтоор нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгслийн тоог нэмэгдүүлэх, мөн хилийн хяналтын албан хаагч нарын оролцоог багасгах зорилгоор автозамын	ТБГ,ХСХОГ	100%	70%	

					<p>буй уул уурхай, эрдэс бүтээгдэхүүнээс дээж авч шинжлэн, татварыг бүрэн ногдуулах нөхцөл бүрдсэн байна.</p>	<p>хилийн боомтуудад орчин үеийн тоног төхөөрөмж суурилуулахаар төлөвлөсөн. Үүнд:Рентген: 5-12 км цагийн хурдтай явж байгаа тээврийн хэрэгсэлд ачсан барааг шалгах эхний ИСБ-А рентгенийг Шивээхүрэн боомтод суурилуулсан бөгөөд дараагийн рентгенийг Боршоо боомтод суурилуулахаар төлөвлөн 2022 оны 9 дүгээр сард үйлдвэрлэгч компанийн мэргэжилтнүүд байршлыг тодорхойлсон. Байршил тодорхойлсон мэдээллийг үндэслэн ОХУ-ын үйлдвэрлэгч компани экспортын бичиг баримтаа бүрдүүлсний дараа ачилт хийгдэнэ;Ухаалаг гарцын систем: Гашуунсухайт боомтын ойролцоо байгуулагдсан чингэлэг терминал гаалийн хяналтын бүсэд ухаалаг гарцын системийн тоног төхөөрөмжүүдийг суурилуулсан. Шивээхүрэн боомтын бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор улсын хилээр орох, гарах чиглэлд тус бүр 1 буюу нийт 2 эгнээ замд ухаалаг гарцын тоног төхөөрөмж суурилуулж, хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийг сайжруулахаар ажиллаж байна.Түүнчлэн хилийн боомтын шинэчлэл төслийн хүрээнд гаалийн нэвтрэх хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор гадаад болон дотоод эх үүсвэрээс тоног төхөөрөмжийн шинэчлэлтийг хийхэд 120,0 тэрбум төгрөгийг олгохоор төлөвлөсөн. 2022 оны 11-р сарын 22-ны өдрийн байдлаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаас 2.0 тэрбум төгрөгийн санхүүжилт гаргаж, барьцаа хөрөнгийн данснаас 5 тэрбум төгрөг чөлөөлсөн.</p>			
24	3.1.21. Нийслэлээс 1000 км-ээс дээш алслагдсан бүсэд үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүд 10 дахин бага буюу 1	1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.5.1-д заасны дагуу нийслэл Улаанбаатар	2020 - 2024		<p>Үйл ажиллагааны хэрэгжилтээр</p>	<p>Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.5.1-д заасны дагуу нийслэл Улаанбаатар хотоос 500 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 50 хувиар, 1000 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 90 хувиар татварын хөнгөлөлт үзүүлдэг болсон.</p>	ТБГ	100%	100%

	хувийн татвар төлөх хуулийн хөнгөлөлтийг үргэлжлүүлж, орон нутагт томоохон аж ахуйн нэгж салбараа байгуулахыг санхүү, татварын бодлогоор дэмжиж, бүсийн нэмэгдэл олгоно.	хотоос 500 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 50 хувиар, 1000 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 90 хувиар татварын хөнгөлөлт үзүүлдэг болно.							
25	3.2.8. Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулна:	2.1. Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах, дамжуулах хоолой барих санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэж, бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэнэ.	2020 - 2024		Дамжуулах хоолойн инженер техникийн зураг төслийг боловсруулах, батлуулах ажлыг зохион байгуулж, барилга угсралтын ажлыг эхлүүлсэн байна. 40%	Түүхий тос дамжуулах хоолой санхүүжилт шийдэгдэж, гүйцэтгэгчээр БНХАУ-ын Норико интернэйшнл кооперэйшн компани шалгарч зураг төслийг боловсруулах, батлуулах ажлыг зохион байгуулж, барилга угсралтын ажил эхлүүлсэн.	ХСХОГ, СБГ	90%	70%
26	боловсруулах үйлдвэрийг барьж байгуулна:	2.2. Дамжуулах хоолой барих төслийн санхүүжилтийг эх үүсвэрийг шийдвэрлэж, трассын дагуух газрыг улсын тусгай хэрэгцээнд авах ажлыг зохион байгуулна	2020 - 2024		-	Холбогдох орон нутгийн төрийн байгууллагуудад албан бичиг хүргүүлсэн. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэр гарна. Дамжуулах хоолойн трассыг хээрийн судалгааны ажлын үр дүнд эцэслэн тодорхойлж, холбогдох орон нутгийн удирдлагуудад байршлын солбицлуудын мэдээллийг хүргүүлж, зурвасын дагуух газрыг улсын тусгай хэрэгцээнд авахаар ажиллаж байна	ХСХОГ, СБГ	90%	50%
27	3.6.1. Эдийн засгийн өсөлтийг хангах, экспортыг	5.1. Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн замаас	2022 - 2023		115,682.9	Концесс эзэмшигч автозамын ажлыг хийж дуусгаагүй байна. Автозамын ажил дуусж, замыг улсын комисст хүлээлгэн өгсөн тохиолдолд	ХСХОГ	100%	50%

	нэмэгдүүлэх зам тээврийн сүлжээг өргөжүүлнэ:	Өлзийт сум, Өлзийт сумаас Мөрөн-Тариалан чиглэлийн замын төгсгөлийг холбох 120км хатуу хучилттай авто зам төсөл/Концессын эргэн төлөлт/				ЭЗХЯ-ны саналыг үндэслэн улсын төсвөөс эргэн төлөлтийг хийх боломжтой юм.			
28		5.3. Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км хатуу хучилттай авто зам төсөл /Концессын эргэн төлөлт/	2020 - 2023		152,015.0	Концессын "барих-шилжих" төрлөөр хэрэгжүүлсэн тус төсөлд 2022 онд 94.5 тэрбум төгрөг батлагдсанаас 11-р сарын 22-ны өдрийн байдлаар 85.0 тэрбум төгрөг олгосон.	ХСХОГ	90%	90%
29		5.4. Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто зам төсөл /Концессын эргэн төлөлт/	2020 - 2022		128,982.7	Концессын "барих-шилжих" төрлөөр хэрэгжүүлсэн тус төсөлд 2022 онд 87.6 тэрбум төгрөг батлагдсанаас 11-р сарын 22-ны өдрийн байдлаар 75.7 тэрбум төгрөг олгосон.	ХСХОГ	90%	90%
30		5.5. Өмнеговь аймгийн төвийг Нийслэлтэй холбосон авто замын "Шар тээг"-ийн уулзвараас Цогтцэций сумын төв хүртэлх 59.6 км хатуу хучилттай авто зам төсөл	2020 - 2022		102,209.0	Концессын "барих-шилжих" төрлөөр хэрэгжүүлсэн тус төсөлд 2022 онд 22.9 тэрбум төгрөг батлагдсанаас 11-р сарын 22-ны өдрийн байдлаар 22.9 тэрбум төгрөг олгож 2022 онд олгох санхүүжилтийг бүрэн олгосон болно.	ХСХОГ	100%	100%

		/Концессын эргэн төлөлт/							
31	3.7.5. Орхоны хөндийд шинэ хотын суурьшлын бүсийн байршлыг судалж, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулна.	1. Орхоны хөндийд шинэ хотын суурьшлын бүсийн байршлыг судлан сонгох, шинэ хот байгуулахад шаардлагатай техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулна.	2020 - 2024		-	2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар БХБС-ын багцад батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улсын хэмжээнд/” төсөл, арга хэмжээний хүрээнд энэхүү төслийн төсөвт өртөг 400.0 сая төгрөг, 2022 онд санхүүжигдэх дүн 261.0 сая төгрөг батлагдаж, 11-р сарын 22-ны өдрийн байдлаар 120.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон.	ХСХОГ	100%	70%
ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО									
32	4.1.9. Мэдээллийн технологийн энтрепренёр, гарааны бизнес эрхлэгчдийг дэмжиж, үндэсний тоон контентыг хөгжүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулна.	1. Үндэсний контент үйлдвэрлэлийн төв байгуулах ТЭЗҮ боловсруулна.	2021 - 2022		ТЭЗҮ боловсруулсан байна.	УИХ-аар батлагдсан 2023 оны төсвийн тухай хуульд ЭЗХС-ын багцад “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улсын хэмжээнд/” төсөл, арга хэмжээнд 40,0 тэрбум төгрөг батлагдсан. Энэхүү төслийн хүрээнд ТЭЗҮ боловсруулахад шаардагдах хөрөнгийн асуудлыг судлах нь зүйтэй.	ХСХОГ	90%	50%
33	4.1.10. Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт,	1. 4.1.10.Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт,	2021 - 2024		Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбоно.	2022 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар бүх шатны төсвийн 4320 байгууллага, 182.3 мянган албан хаагчдын үндсэн мэдээлэл, үндсэн цалин хөлс, нэмэгдэл цалин хөлсний мэдээллийг ТА3-ийн ХНУМТ цахим системд бүртгэж ТАЦНС-д цахимаар хүлээн авч 1,761.8 тэрбум төгрөгийн цалин хөлсийг тооцоолсон байна.	ТСГ	100%	100%

	хяналтыг сайжруулна.	хяналтыг сайжруулна.							
34	4.2.2. Төрийн захиргааны байгууллагад чиг үүргийн иж бүрэн шинжилгээ хийж, чиг үүргийг оновчтой болгож, ажил үүргийн давхцалыг арилгах бодлогын шинэчлэлийг эхлүүлнэ.	3. Төрийн байгууллагад "цалингийн нэгдсэн систем"-ийг нэвтрүүлнэ.	2021 - 2024		Байгууллагын тоо 3509	Бүх шатны төсвийн 4320 байгууллага ТАЦНС-ээр цалингаа тооцоолж, ЭБС системээр баталгаажуулан Монгол банкны багцын гүйлгээний системээр цалин хөлсийг цахимаар олгож хэвшсэн.	ТСГ	100%	100%
35	4.2.5. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.	3. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд өөрчлөлт оруулна. Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх талаар сургалт, сурталчилгааны хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана.	2021 - 2024		Сургалт, сурталчилгааг явуулснаар үнэт зүйл, үндсэн зарчмаа хэрэгжүүлж, манлайллыг хангаснаар ёс зүйн зөрчил буурна.	Сангийн яамны Хүний Нөөцийн Хөгжлийн хөтөлбөр /2019-2029/-ийг 2019 онд батлуулсан. Хөтөлбөрийн хүрээнд "Эрүүл мэнд" болон "Нийгмийн баталгааг хангах" дэд хөтөлбөрийг боловсруулж, 2020 онд Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. "Карьер хөгжил" болон "Сургалт хөгжил" дэд хөтөлбөрийг боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн Б40 тоот тушаалаар батлуулсан. "Эрүүл мэнд" болон "Нийгмийн баталгаа" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан, 2021 оны 4 дүгээр 09-ний өдөр, мөн ТНБД-аар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Дэд хөтөлбөрүүдийн хүрээнд дараах ажлыг гүйцэтгээд байна. Үүнд: - "Сургалт хөгжил" дэд хөтөлбөрийн хүрээнд яамны 2021 оны сургалтын төлөвлөгөөг батлуулж, 2021 оны 3 дугаар улирлын байдлаар давхардсан тоогоор 72 албан хаагчийг цахим болон танхимын сургалтад хамруулсан болно. - "Эрүүл мэнд" дэд хөтөлбөрийн хүрээнд яамны нийт албан хаагчдыг Ковид-19-ын эсрэг 3 дахь тун вакцинд бүрэн хамруулсан. Мөн дархлаажуулалтын	ТЗУГ	100%	70%

						аяныг улирал тутам буюу нийт 3 удаа зохион байгуулж, албан хаагчдад витамин, тан, ансь, чацаргана, амны хаалт, гар ариутгагч зэрэг зүйлсээр хангасан. Албан хаагчдыг халдварын эрсдэлээс хамгаалж, хуваарь гарган, цахимаар гэрээсээ ажиллах боломжийг бүрэн ханган ажиллаж байна. Албан хаагчдыг эрүүл мэндийн аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бие, сэтгэлзүйн хувьд эрүүл байх, ажлын бүтээмжтэй, сэтгэл ханамжтай ажиллахад нь дэмжлэг үзүүлж, эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээг эрсдэлгүй, түргэн шуурхай хүргэх, эмчийн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх зорилгоор эмч ажиллуулах, яамны байранд өрөө гаргах, эмнэлгийн анхан шатны тусламжийн хэрэглэл худалдан авч тохижуулах танилцуулгыг батлуулан, эмчийг сонгох, эмчийн өрөөг тохижуулах ажлыг зохион байгуулж байна.			
36	4.5.5. Америкийн Нэгдсэн Улс, Япон, Европын Холбоо, Энэтхэг, Бүгд Найрамдах Солонгос Улс, Турк зэрэг өрнө, дорнын улс, холбоотой "гуравдагч хөрш"-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцааг өргөжүүлэн, эдийн засгийн хамтын ажиллагааг бэхжүүлж, бусад улстай харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх	4. БНЭУ-тай Стратегийн түншлэлийг улам бэхжүүлж, БНЭУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	2021 - 2024	Газрын тосны үйлдвэрийн төслийн ажил урагшилна.	БНЭУ-ын санхүүжилтээр хэрэгжиж буй "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийн санхүүжилтийн хүсэлтийг тухай бүрд нь шийдвэрлэсэн. 2021-2022 онд нийт 35.9 тэрбум төгрөгийн импортын татвараас чөлөөлсөн. Дамжуулах хоолойн трассын дагуу газрыг улсын тусгай хэрэгцээнд авах ажиллагаанд дэмжлэг үзүүлж байна.	ХСХОГ	100%	90%	

	чиглэлээр идэвхтэй ажиллана.								
ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО									
37	5.1.12. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлж, хүлэмжийн хийн ялгарлыг 12.3 хувиар бууруулна.	2. Уур амьсгалын өөрчлөлтийн Парисын хэлэлцээрт оруулах үндэсний тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилтийг хангана.	2020 - 2024		Эрчим хүч, хөдөө аж ахуй, барилга, тээвэр, аж үйлдвэр, хог хаягдлын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулж, нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлсэн байна.	Монгол Улсын Засгийн газар, АНУ-ын Мянганы сорилтын корпорац хооронд "Мянганы сорилтын компакт гэрээ II"-г 2018.07.27-ны өдөр байгуулж, УИХ-аар 2019.01.31-ний соёрхон баталсан. Компакт гэрээгээр Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх төслийг 2021-2026 онд Мянганы Сорилтын Корпорацын 350.0 сая ам.долларын буцалтгүй тусламж, Монгол Улсын Засгийн газрын 111.76 сая ам.доллар нийт 462 сая ам долларын санхүүжилтээр хэрэгжүүлж байна. Энэ нь Улаанбаатар хотын ирээдүйн нийт ус хангамжийг асуудлыг шийдвэрлэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, түүнийг даван туулах чадавхыг бий болгоход чухал үүрэгтэй хөрөнгө оруулалт болно.	ХСХОГ	100%	100%
ЗУРГАА. НИЙСЛЭЛ БА БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО									
38	6.2.6. Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, тус сангийн үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх, ил тод байдлыг сайжруулах, олон нийт оролцох, мэдээлэл хүргэх дэвшилтэт арга хэлбэрийг нэвтрүүлнэ.	1. Орон нутгийн хөгжлийн сангийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээг 21 аймгийн 330 суманд хийж, болзол хангасан сумдад өнгөрсөн оны ОНХС-ийн санхүүжилтийн 25%-тай тэнцэх хэмжээний "урамшуулал" олгоно. ОНХС-ийн удирдлагын мэдээллийн системийг	2020 - 2024		ОНХС-ийн үр дүнг үнэлж дүгнэх, ил тод байдлыг сайжруулах, олон нийт оролцох, мэдээлэл хүргэх чанарыг дээшлүүлсэн байна.	Орон нутгийн хөгжлийн сангийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээг 21 аймгийн 330 суманд хийж, болзол хангасан 215 суманд нийт 7 тэрбум төгрөгийн "урамшуулал" олгохоор төлөвлөж, 2022 оны 5-р сард сумдад урамшууллыг бүрэн шилжүүлсэн. ОНХС-ийн удирдлага мэдээллийн систем (www.onhs.mof.gov.mn)-ийг шинэчлэн хөгжүүлж, ашиглалтад оруулсан ба тус мэдээллийн системээс иргэд ОНХС-ийн төсөв, иргэдээс гарсан саналаас батлагдах хүртлэх үе шат бүрийн мэдээлэл, тэдгээрийн хэрэгжилтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тоон болон зураг, файл, текст байдлаар авах боломжтой. Сангийн яамнаас системд аймаг, нийслэлийн ОНХС-ийн дата мэдээллийг бүрэн оруулах чиглэлийг өгч ажиллаж байна. Мөн Нийслэлийн ОНХС-ийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор НЗДТГ-тай хамтран ОНХС-ийн гар	ТБТГ	100%	90%

		боловсруулж, үр дүнг үнэлж дүгнэх, ил тод байдлыг сайжруулах, олон нийт оролцох, мэдээлэл хүргэх чанарыг сайжруулна.				утасны аппликейшнийг нэвтрүүлэх, аппликейшнээр дамжуулан иргэдийн саналыг цахимаар авах, иргэдэд мэдээлэл түгээх ажлыг хэрэгжүүлж байна.			
--	--	--	--	--	--	--	--	--	--

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТ

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин 2022 он	Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Мэдээлэл цуглуулах давтамж	Хэрэгжилт	Хариуцсан газар
ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО								
3.1. Санхүү, эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг хангах бодлого хэрэгжүүлнэ.								
1	Засгийн газраас эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээл, санхүүжилтийн эх үүсвэрийг хугацаанаас нь өмнө төлүүлэх, хямдруулан худалдах, дампуурсан банкнуудын эрх хүлээн авагчдаас авах төрийн байгууллагуудын авлагыг Монголбанкинд шилжүүлэх зэргээр Засгийн газрын санхүүгийн нөөцийг нэмэгдүүлсэн хувь	хувь	30	50	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	"Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгагдсан санхүүгийн хөрөнгө буюу авлагаас Сангийн яамны хяналтад байдаг Засгийн газраас эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээл, санхүүжилтийн авлага 2019 оны жилийн эцсийн дүнгээр 206.2 тэрбум төгрөг, үүнээс хугацаа хэтэрсэн авлага 137.1 тэрбум төгрөг байсан бөгөөд 2022 оны эхний хагас жилийн байдлаар нийт авлага 74.8 тэрбум төгрөг үүнээс хугацаа хэтэрсэн авлага 20.4 тэрбум төгрөг болж 72.7 хувиар буурсан буюу мөн хэмжээгээр Засгийн газрын санхүүгийн нөөцийг нэмэгдүүлсэн байна. Энэхүү үзүүлэлт нь 2022 оны хүрэх түвшин буюу 50 хувийг давж биелсэн байна.	СБГ /100%/
ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО								
Тэргүүлэх зорилт №5.1. Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ								
2	Засгийн газрын ногоон худалдан авалтын эзлэх хувь	хувь	0	4	-	Жилд нэг удаа	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын ээлжит бус чуулганы хуралдаанаар хэлэлцэж, 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдөр баталсан. Тус хуулиар "Үндэсний үйлдвэрлэгчийн ногоон бүтээгдэхүүнийг төсвийн хөрөнгөөр нэн тэргүүнд худалдан авах эрх зүйн тогтолцоо бий болгох" зорилтын хүрээнд бүх шатны захиалагч байгууллагууд техникийн тодорхойлолтоо боловсруулахдаа тогтвортой худалдан авалтын шалгуур үзүүлэлтийг ашиглахыг дараах байдлаар хуульчилж өгсөн. Үүнд: хуулийн 5	ХЭЗГ /Үнэлэх боломжгүй/

						<p>дугаар зүйлийн 5.1.28. “ногоон худалдан авах ажиллагаа” гэж эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг хэлнэ. 11.1.1. Захиалагч техникийн тодорхойлолтыг бэлтгэхдээ тухайн бараа, ажил, үйлчилгээг гадаад шинж чанарын үзүүлэлтээр бус, зориулалт, эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээ, ашиглалт, чанарын түвшин, техникийн болон тухайн бараа, ажил, үйлчилгээ нь байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн шалгуур үзүүлэлтээр тодорхойлно. Монгол Улсад ногоон худалдан авах ажиллагааг нэвтрүүлэх зах зээлийн судалгаа хийж бичгийн цаас, принтерийн хор болон хөнгөн бетон блокны ногоон худалдан авалтын шалгуур үзүүлэлтийг бэлтгэж цахим системд байршуулж, олон нийтэд нээлттэй мэдээлсэн. Хуулийн дээрх нэмэлт, өөрчлөлттэй холбоотой төрийн худалдан авалтыг ногоон худалдан авалтад үе шаттайгаар шилжүүлж, хувийн хэвшлийг дэмжих тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд нэн тэргүүнд худалдан авах ажиллагааны тендерийн жишиг баримт бичгүүдийг шинэчлэн батлуулсан.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсны дагуу хуулийн 49.5-д зааснаар 2022 онд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний ТЕЗ нарын тайланд үндэслэн ногоон худалдан авах ажиллагааны хэрэгжилттэй холбогдох мэдээллийг гаргах болно./49.5.Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг захиалагч тухайн жилийн 12 дугаар сарын 1-ний дотор төсвийн ерөнхийлөн захирагчид, ерөнхийлөн захирагч нь дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор төсвийн</p>
--	--	--	--	--	--	--

						асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана./"	
--	--	--	--	--	--	--	--